**БАЯНХОНГОР АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

**САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ**

# Баянхонгор аймгийн Эрдэнэцогт сумын ЗДТГ-ын газрын 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

**Аудитын код: БНА-2025/174/НА-СТА-ТШЗ**

| | |
|---|---|
| Цахим хуудас: www.audit.mn<br>Баянхонгор хот<br>2025 оны 02 дугээр сарын 15 | Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газрын дарга, Тэргүүлэх аудитор: Б.Мөнхбат<br>Утас: 70442584 Цахим хаяг: munkhbatb@audit.gov.mn<br>Аудитын менежер: М.Алтантуяа<br>Утас: 70442424 Цахим хаяг: altantuyam@audit.gov.mn<br>Аудитор: Н.Бүнчинсүрэн<br>Утас: 99049866 Цахим хаяг: bunchinsurenn@audit.gov.mn |

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

## НЭГ. ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ

БАЯНХОНГОР АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
310 дугаар байр, Лувсанданзанжанцангийн
өргөн чөлөө 3 дугаар гудамж, Номгон 1 дүгээр баг,
Баянхонгор сум, Баянхонгор аймаг, 64101
Утас: (976) 70442584
Цахим шуудан:procurement. bayankhongor@audit.gov.mn

2025.02.25 № 2/45

танай___________-ны № _____________ -т

БАЯНХОНГОР АЙМГИЙН
ЭРДЭНЭЦОГТ СУМЫН ЗАСАГ
ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН ДАРГА
Р.БОЛОРМАА ТАНАА

### Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Баянхонгор аймгийн Эрдэнэцогт сумын ЗДТГ-ын 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Бидний дүгнэлтээр санхүүгийн тайлангууд нь 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн санхүүгийн байдал болон тайлант жилийн эцсээрх санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, төсвийн гүйцэтгэлийг бүх материаллаг талаар нь Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв илэрхийлсэн байна.

### Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан.

Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

### Асуудлыг онцлон тэмдэглэсэн хэсэг

Байгууллагын удирдлага нь санхүүгийн тайлангаа бэлтгэхдээ нягтлан бодох бүртгэлийн тасралтгүй байх зарчмыг ашигласан байна. Цаашид тус байгууллагын талаар чиг үүрэг нь өөрчлөгдөж татан буугдах, нэгдэх асуудал гараагүй тул байгууллагын тасралтгүй байдлын талаар нөхцөл үүсээгүй гэж үзсэн болно.

### Аудитын гол асуудал

Аудитын гол асуудал гэдэг нь тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад хамгийн чухал нөлөөтэй хэмээн мэргэжлийн шүүн тунгаалтаар бидний авч үзсэн асуудал байна. Гол асуудлыг санхүүгийн тайлангийн аудитын хүрээнд бүхэлд нь харгалзаж, аудитын санал дүгнэлтээ илэрхийлэхэд авч үзсэн бөгөөд энэхүү гол асуудлын талаар бид тусад нь дүгнэлт гаргахгүй.

### Бусад асуудлын хэсэг

5020282

d:\2025 он\бичиг хэрэг\тоот\2. а4-албан тоот.docx

Байгууллагын удирдлага бусад мэдээлэлтэй холбоотой үүрэг хариуцлагыг хүлээнэ. Байгууллагын жилийн гүйцэтгэлийн төлөвлөгөөнд 4 зорилтын хүрээнд 32 арга хэмжээг хэрэгжүүлэхээр тусгаж, гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлтийг 92.5 хувиар үнэлсэн байна.

Шалгагдагч байгууллагын санхүүгийн тайлангаас бусад үйл ажиллагааны тайлан, мэдээ, гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлт зэрэг мэдээлэлтэй танилцсан. Танилцахад материаллаг буруу илэрхийлсэн зүйл илрээгүй.

**Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага**

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

**Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР Б.МӨНХБАТ

## ХОЁР.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

**2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан** **/төгрөгөөр/**

| Дансны код | Балансын үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл |
|---|---|---|---|
| **1** | **ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН** | **211313757.00** | **231860170.00** |
| **33** | **АВЛАГА** | 33,139,744.00 | 45,716,578.00 |
| 33100 | Ажиллагчидтай холбогдсон авлага | 00.00 | 768,401.00 |
| 33300 | Татаас, санхүүжилтийн авлага | 00.00 | 6,808,433.00 |
| **335** | **Бусад авлага** | 33,139,744.00 | 38,139,744.00 |
| 3351 | Байгууллагаас авах авлага | 00.00 | 5,000,000.00 |
| 3352 | Хувь хүмүүсээс авах авлага | 33,139,744.00 | 33,139,744.00 |
| **35** | **БАРАА МАТЕРИАЛ** | 178,174,013.00 | 186,143,592.00 |
| **354** | **Хангамжийн материал** | 172,875,394.00 | 180,844,973.00 |
| 35410 | Бичиг хэргийн материал | 1,897,730.00 | 1,172,730.00 |
| 35420 | Аж ахуйн материал | 169,798,914.00 | 178,527,243.00 |
| 35440 | Түлш, шатах тослох материал | 1,178,750.00 | 1,145,000.00 |
| 35600 | Мал амьтад | 5,298,619.00 | 5,298,619.00 |
| **2** | **ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН** | **2,677,831,232.25** | **2,942,943,638.27** |
| **39** | **ҮНДСЭН ХӨРӨНГӨ** | 2,677,831,232.25 | 2,942,943,638.27 |
| **392** | **Биет хөрөнгө** | 2,618,264,773.85 | 2,883,414,992.35 |
| 39201 | Барилга, байгууламж, орон сууц | 2,814,246,089.69 | 3,059,254,268.69 |
| 39202 | Хуримтлагдсан элэгдэл | -417,888,050.30 | -501,189,605.58 |
| 39203 | Авто-тээврийн хэрэгсэл | 177,172,800.00 | 217,072,800.00 |
| 39204 | Хуримтлагдсан элэгдэл | -114,889,948.22 | -96,451,613.62 |
| 39205 | Машин тоног төхөөрөмж (компьютер) | 244,526,518.00 | 296,686,118.00 |
| 39206 | Хуримтлагдсан элэгдэл | -117,894,786.22 | -143,754,634.92 |
| 39207 | Тавилга, аж ахуйн эд хогшил | 58,696,300.00 | 58,696,300.00 |
| 39208 | Хуримтлагдсан элэгдэл | -26,378,749.10 | -32,486,226.22 |
| 39217 | Ном | 674,600.00 | 25,587,586.00 |
| **393** | **Биет бус хөрөнгө** | 59,566,458.40 | 59,528,645.92 |
| 39301 | Програм хангамж | 552,500.00 | 552,500.00 |
| 39302 | Хуримтлагдсан элэгдэл | -376,041.60 | -413,854.08 |
| 39303 | Бусад биет бус хөрөнгө | 59,390,000.00 | 59,390,000.00 |
| **3** | **НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II** | **2,889,144,989.25** | **3,174,803,808.27** |
| **4** | **НИЙТ ӨР ТӨЛБӨР** | **1,678,777.00** | **00.00** |
| **41** | **БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР** | 1,678,777.00 | 00.00 |
| **413** | **Өглөг** | 1,678,777.00 | 00.00 |
| 41310 | Ажилчидтай холбогдсон өглөг | 1,678,777.00 | 00.00 |
| **5** | **ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН** | **2,887,466,212.25** | **3,174,803,808.27** |
| **51** | **Засгийн газрын хувь оролцоо** | 2,887,466,212.25 | 3,174,803,808.27 |
| 511 | Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан | 494,690,961.00 | 494,690,961.00 |
| 51101 | Өмч: - төрийн | 494,690,961.00 | 494,690,961.00 |
| **512** | **Хуримтлагдсан үр дүн** | 2,247,542,658.44 | 2,534,880,254.46 |
| 51210 | Өмнөх үеийн үр дүн | 2,247,542,658.44 | 2,247,542,658.44 |
| 51220 | Тайлант үеийн үр дүн | 00.00 | 287,337,596.02 |
| 51300 | Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү | 145,232,592.81 | 145,232,592.81 |
| **6** | **ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V** | **2,889,144,989.25** | **3,174,803,808.27** |

**2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан** /төгрөгөөр/

| Дансны код | Үзүүлэлт | Өмнөх оны гүйцэтгэл | Тайлант оны гүйцэтгэл |
|---|---|---|---|
| **1** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)** | **888,143,018.00** | **1,529,255,612.50** |
| **12** | **ТАТВАРЫН БУС ОРЛОГО** | **79,031,930.00** | **456,275,665.00** |
| **120** | **Нийтлэг татварын бус орлого** | 79,031,930.00 | 456,275,665.00 |
| 120004 | Төсөв байгууллагын өөрийн орлого | 2,000,000.00 | 456,275,665.00 |
| 1200041 | Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 2,000,000.00 | - |
| 1200042 | Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих | - | 604,000.00 |
| 120017 | Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого-Үндсэн хөрөнгө | 14,960,000.00 | 391,580,765.00 |
| 120018 | Үндсэн төлбөргүй хүлээг авсан орлого-Бараа материал | 62,071,930.00 | 64,090,900.00 |
| **13** | **ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО** | **809,111,088.00** | **1,072,979,947.50** |
| **1311** | **Нэмэлт санхүүжилтийн орлого** | 102,016,888.00 | 36,864,847.50 |
| 131104 | Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 93,575,682.00 | 30,468,407.50 |
| 131105 | Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого | 8,441,206.00 | 6,396,440.00 |
| **1320** | **Орон нутгийн төсвөөс санхүүжих** | 707,094,200.00 | 1,036,115,100.00 |
| 132001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/ | 707,094,200.00 | 1,036,115,100.00 |
| **2** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН** | **848,035,357.82** | **1,241,918,016.48** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **848,035,357.82** | **1,241,918,016.48** |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | 802,593,107.05 | 1,091,074,346.87 |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | 425,312,329.65 | 626,444,010.00 |
| 210101 | Үндсэн цалин | 425,312,329.65 | 626,444,010.00 |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | 53,409,185.00 | 78,341,323.00 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 53,409,185.00 | 78,341,323.00 |
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | 71,574,316.58 | 84,885,261.75 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 5,370,716.58 | 6,125,861.75 |
| 210302 | Түлш, халаалт | 65,399,600.00 | 77,862,400.00 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 804,000.00 | 897,000.00 |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | 42,047,712.00 | 43,286,262.00 |
| 210401 | Бичиг хэрэг | 4,325,850.00 | 8,074,820.00 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 19,125,331.00 | 20,827,335.00 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 3,133,400.00 | 1,466,291.00 |
| 210404 | Ном, хэвлэл | - | 184,800.00 |
| 210405 | Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал | 7,401,000.00 | 7,616,560.00 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 4,282,800.00 | 5,116,456.00 |
| 210408 | Бараа материал акталсны зардал | 3,779,331.00 | - |
| **2105** | **Нормативт зардал** | - | 27,653,500.00 |
| 210501 | Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл | - | 4,623,000.00 |
| 210502 | Хоол, хүнс | - | 23,030,500.00 |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | 21,790,800.00 | 2,912,500.00 |
| 210601 | Багаж, техник, хэрэгсэл | 5,071,730.00 | - |
| 210604 | Урсгал засвар | 16,719,070.00 | 2,912,500.00 |
| **2107** | **Томилолт, зочны зардал** | 12,472,000.00 | 21,465,298.00 |
| 210702 | Дотоод албан томилолт | 12,472,000.00 | 21,465,298.00 |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | 13,447,281.00 | 33,480,466.50 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 11,274,712.00 | 30,510,466.50 |
| 210802 | Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох | 500,000.00 | - |
| 210804 | Тээврийн хэрэгслийн татвар | 10,000.00 | - |

| | | | |
|---|---|---|---|
| 210805 | Тээврийн хэрэгслийн оношлогоо | 20,000.00 | - |
| 210806 | Мэдээлэл, технологийн үйлчилгээ | 1,642,569.00 | 2,970,000.00 |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | 162,539,482.82 | 172,605,725.62 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 35,479,296.00 | 35,837,366.64 |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 150,000.00 | 1,800,000.00 |
| 210903 | Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол | 126,910,186.82 | 134,968,358.98 |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | 45,442,250.77 | 150,843,669.61 |
| **2131** | **Засгийн газрын урсгал шилжүүлэг** | - | 29,617,000.00 |
| 213101 | Засгийн газрын дотоод шилжүүлэг | - | 29,617,000.00 |
| **2132** | **Бусад урсгал шилжүүлэг** | 2,457,000.00 | 14,436,000.00 |
| 213207 | Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж | - | 13,971,000.00 |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 2,457,000.00 | 465,000.00 |
| **2134** | **Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт** | 42,985,250.77 | 106,790,669.61 |
| 213403 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 38,267,518.77 | 106,790,669.61 |
| 213405 | Нэмэлт дансны төвлөрүүлэх шилжүүлэг | 4,717,732.00 | |
| **3** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)** | **40,107,660.18** | **287,337,596.02** |
| **225** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН** | 34,486,691.57 | - |
| 225001 | Үндсэн хөрөнгө худалдсаны гарз | 34,486,691.57 | - |
| **4** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)** | (34,486,691.57) | - |
| **5** | **НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)** | **5,620,968.61** | **287,337,596.02** |

**2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан** **/төгрөгөөр/**

| Дансны код | Үзүүлэлт | Өмнөх оны гүйцэтгэл | Тайлант оны гүйцэтгэл |
|---|---|---|---|
| | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ** | | |
| **1** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)** | **820,635,708.00** | **1,073,583,947.50** |
| **12** | **ТАТВАРЫН БУС ОРЛОГО** | **2,044,791.00** | **604,000.00** |
| **120** | **Нийтлэг татварын бус орлого** | 2,044,791.00 | 604,000.00 |
| 120004 | **Төсөв байгууллагын өөрийн орлого** | 2,044,791.00 | 604,000.00 |
| 1200041 | Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 2,044,791.00 | 00.00 |
| 1200042 | Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 00.00 | 604,000.00 |
| **13** | **ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО** | **818,590,917.00** | **1,072,979,947.50** |
| **1311** | **Нэмэлт санхүүжилтийн орлого** | 111,496,717.00 | 36,864,847.50 |
| 131104 | Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 93,575,682.00 | 30,468,407.50 |
| 131105 | Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого | 17,921,035.00 | 6,396,440.00 |
| **1320** | **Орон нутгийн төсвөөс санхүүжих** | 707,094,200.00 | 1,036,115,100.00 |
| 132001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/ | 707,094,200.00 | 1,036,115,100.00 |
| **2** | **НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)** | **749,322,708.00** | **1,065,083,947.50** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **749,322,708.00** | **1,065,083,947.50** |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | **703,937,457.23** | **937,048,844.89** |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | 425,233,147.65 | 629,566,093.00 |
| 210101 | Үндсэн цалин | 288,083,217.15 | 365,291,869.00 |
| 210102 | Нэмэгдэл | 121,764,967.50 | 249,215,724.00 |
| 210104 | Урамшуулал | 15,384,963.00 | 15,058,500.00 |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | 51,573,964.00 | 77,508,018.00 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 34,909,175.00 | 53,814,668.00 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 4,164,901.00 | 6,074,778.00 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 3,318,111.00 | 2,846,580.00 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 816,092.00 | 1,813,149.00 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 8,365,685.00 | 12,958,843.00 |
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | 71,574,316.58 | 84,885,261.75 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 5,370,716.58 | 6,125,861.75 |
| 210302 | Түлш, халаалт | 65,399,600.00 | 77,862,400.00 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 804,000.00 | 897,000.00 |

| | | | |
|---|---|---|---|
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | 33,542,931.00 | 33,901,756.00 |
| 210401 | Бичиг хэрэг | 4,272,850.00 | 3,949,820.00 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 17,467,381.00 | 15,302,500.00 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 1,054,400.00 | 960,291.00 |
| 210404 | Ном, хэвлэл | - | 184,800.00 |
| 210405 | Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал | 7,341,000.00 | 7,774,960.00 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 3,407,300.00 | 5,729,385.00 |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | 17,938,730.00 | 4,042,500.00 |
| 210601 | Багаж, техник, хэрэгсэл | 202,730.00 | 200,000.00 |
| 210604 | Урсгал засвар | 17,736,000.00 | 3,842,500.00 |
| **2107** | **Томилолт, зочны зардал** | 12,472,000.00 | 21,125,298.00 |
| 210702 | Дотоод албан томилолт | 12,472,000.00 | 21,125,298.00 |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | 50,163,072.00 | 39,266,466.50 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 45,911,503.00 | 34,902,466.50 |
| 210802 | Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох | 500,000.00 | 800,000.00 |
| 210804 | Тээврийн хэрэгслийн татвар | 10,000.00 | - |
| 210805 | Тээврийн хэрэгслийн оношлогоо | 20,000.00 | - |
| 210806 | Мэдээлэл, технологийн үйлчилгээ | 3,721,569.00 | 3,564,000.00 |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | 41,439,296.00 | 46,753,451.64 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 41,289,296.00 | 44,953,451.64 |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 150,000.00 | 1,800,000.00 |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | **45,385,250.77** | **128,035,102.61** |
| **2132** | **Бусад урсгал шилжүүлэг** | 2,400,000.00 | 14,436,000.00 |
| 213207 | Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж | - | 13,971,000.00 |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 2,400,000.00 | 465,000.00 |
| **2134** | **Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт** | 42,985,250.77 | 113,599,102.61 |
| 213403 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 38,267,518.77 | 106,790,669.61 |
| 213405 | Нэмэлт санхүүжилт төвлөрүүлэх шилжүүлэг | 4,717,732.00 | 6,808,433.00 |
| **3** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)** | **71,313,000.00** | **8,500,000.00** |
| **22** | **ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ** | **71,313,000.00** | **8,500,000.00** |
| **2200** | **Дотоод эх үүсвэрээр** | 71,313,000.00 | 8,500,000.00 |
| 225106 | Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал | 71,313,000.00 | 8,500,000.00 |
| **6** | **ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)** | **-71,313,000.00** | **-8,500,000.00** |
| **9** | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл** | 00.00 | 00.00 |
| **10** | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл** | 00.00 | 00.00 |

## 2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

/ төгрөгөөр /

| Код | Үзүүлэлт | Засгийн газрын оруулсан капитал | Дахин үнэлгээний нөөц | Хуримтлагдсан дүн | Засгийн газрын хувь оролцооны нийт дүн |
|---|---|---|---|---|---|
| C01 | **2023 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл** | 494,690,961.00 | 145,232,592.81 | 2,241,921,689.83 | 2,881,845,243.64 |
| C07 | Тайлант үеийн үр дүн | 00.00 | 00.00 | 5,620,968.61 | 5,620,968.61 |
| C08 | **2023 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл** | **494,690,961.00** | **145,232,592.81** | **2,247,542,658.44** | 2,887,466,212.25 |
| D01 | **2023 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл** | **494,690,961.00** | **145,232,592.81** | **2,247,542,658.44** | 2,887,466,212.25 |
| D02 | Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт | 00.00 | 00.00 | 00.00 | 00.00 |
| D03 | **Дахин илэрхийлсэн үлдэгдэл** | **494,690,961.00** | **145,232,592.81** | **2,247,542,658.44** | 2,887,466,212.25 |
| D08 | Тайлант үеийн үр дүн | 00.00 | 00.00 | 287,337,596.02 | 287,337,596.02 |
| D09 | **2024 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл** | **494,690,961.00** | **145,232,592.81** | **2,534,880,254.46** | **3,174,803,808.27** |

## 2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

/ төгрөгөөр /

| Эдийн засгийн ангилал | Үзүүлэлт | Тайлант оны | | | |
|---|---|---|---|---|---|
| | | Батлагдсан төлөвлөгөө | Гүйцэтгэл | Зөрүү | хувь |
| **2** | **НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН** | 1,037,115,100.00 | 929,928,430.39 | 107,186,669.61 | 89.7 |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | 1,037,115,100.00 | 929,928,430.39 | 107,186,669.61 | 89.7 |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | 1,021,544,100.00 | 915,492,430.39 | 106,051,669.61 | 89.6 |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | 677,150,200.00 | 629,566,093.00 | 47,584,107.00 | 93.0 |
| 210101 | Үндсэн цалин | 385,601,300.00 | 365,291,869.00 | 20,309,431.00 | 94.7 |
| 210102 | Нэмэгдэл | 269,321,200.00 | 249,215,724.00 | 20,105,476.00 | 92.5 |
| 210104 | Урамшуулал | 22,227,700.00 | 15,058,500.00 | 7,169,200.00 | 67.7 |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | 86,768,900.00 | 77,508,018.00 | 9,260,882.00 | 89.3 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 58,662,700.00 | 53,814,668.00 | 4,848,032.00 | 91.7 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 6,901,600.00 | 6,074,778.00 | 826,822.00 | 88.0 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 3,450,800.00 | 2,846,580.00 | 604,220.00 | 82.5 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 3,450,800.00 | 1,813,149.00 | 1,637,651.00 | 52.5 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 14,303,000.00 | 12,958,843.00 | 1,344,157.00 | 90.6 |
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | 86,662,400.00 | 84,885,261.75 | 1,777,138.25 | 97.9 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 7,450,000.00 | 6,125,861.75 | 1,324,138.25 | 82.2 |
| 210302 | Түлш, халаалт | 78,212,400.00 | 77,862,400.00 | 350,000.00 | 99.6 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 1,000,000.00 | 897,000.00 | 103,000.00 | 89.7 |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | 43,598,900.00 | 33,901,756.00 | 9,697,144.00 | 77.8 |
| 210401 | Бичиг хэрэг | 4,467,700.00 | 3,949,820.00 | 517,880.00 | 88.4 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 18,600,000.00 | 15,302,500.00 | 3,297,500.00 | 82.3 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 1,555,200.00 | 960,291.00 | 594,909.00 | 61.7 |
| 210404 | Ном, хэвлэл | 200,000.00 | 184,800.00 | 15,200.00 | 92.4 |
| 210405 | Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал | 12,936,000.00 | 7,774,960.00 | 5,161,040.00 | 60.1 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 5,840,000.00 | 5,729,385.00 | 110,615.00 | 98.1 |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | 13,000,000.00 | 12,542,500.00 | 457,500.00 | 96.5 |
| 210601 | Багаж, техник, хэрэгсэл | 9,000,000.00 | 8,700,000.00 | 300,000.00 | 96.7 |
| 210604 | Урсгал засвар | 4,000,000.00 | 3,842,500.00 | 157,500.00 | 96.1 |
| **2107** | **Томилолт, зочны зардал** | 21,222,700.00 | 21,125,298.00 | 97,402.00 | 99.5 |
| 210702 | Дотоод албан томилолт | 21,222,700.00 | 21,125,298.00 | 97,402.00 | 99.5 |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | 12,251,000.00 | 9,210,052.00 | 3,040,948.00 | 75.2 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 7,800,000.00 | 4,846,052.00 | 2,953,948.00 | 62.1 |
| 210802 | Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох | 800,000.00 | 800,000.00 | 0.00 | 100.0 |
| 210806 | Мэдээлэл, технологийн үйлчилгээ | 3,564,000.00 | 3,564,000.00 | 0.00 | 100.0 |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | 80890000.00 | 46753451.64 | 34,136,548.36 | 57.8 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 78,890,000.00 | 46,753,451.64 | 32,136,548.36 | 59.3 |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | 15571000.00 | 14436000.00 | 1,135,000.00 | 92.7 |
| **2132** | **Бусад урсгал шилжүүлэг** | 15,571,000.00 | 14,436,000.00 | 1,135,000.00 | 92.7 |
| 213207 | Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж | 13,971,000.00 | 13,971,000.00 | 0.00 | 100.0 |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 1,600,000.00 | 465,000.00 | 1,135,000.00 | 29.1 |
| | **ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР** | 1,037,115,000.00 | 929,928,430.39 | 107,186,569.61 | 89.7 |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| **1320** | **ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ** | 1,036,115,000.00 | 929,928,430.39 | 106,186,569.61 | 89.8 |
| 132001 | Орон нутгийн төсвөөс | 1,036,115,000.00 | 929,324,430.39 | 106,790,569.61 | 89.7 |
| **120004** | **ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС** | 1,000,000.00 | 604,000.00 | 396,000.00 | 60.4 |
| 1200042 | Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 1,000,000.00 | 604,000.00 | 396,000.00 | 60.4 |
| **6** | **ТӨСВИЙН БУСАД МЭДЭЭЛЛИЙН АНГИЛАЛ** | 1 | 1 | 0.00 | 100.0 |
| **61** | **БАЙГУУЛЛАГЫН ТОО** | 1 | 1 | 0.00 | 100.0 |
| **62** | **АЖИЛЛАГСАДЫН ТОО** | 20 | 20 | 0.00 | 100.0 |
| 620001 | Удирдах ажилтан | 3 | 3 | 0.00 | 100.0 |
| 620002 | Гүйцэтгэх ажилтан | 12 | 12 | 0.00 | 100.0 |
| 620003 | Үйлчлэх ажилтан | 5 | 5 | 0.00 | 100.0 |

**2.5 Нэмэлт дансны тайлан** / төгрөгөөр /

| Дансны код | Үзүүлэлт | Гүйцэтгэл |
|---|---|---|
| | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл** | |
| **I** | **НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН** | **30,056,414.50** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **30,056,414.50** |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | 30,056,414.50 |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | 6,180,094.00 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 6,180,094.00 |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | 23876320.50 |
| **2132** | **Бусад урсгал шилжүүлэг** | 23,876,320.50 |
| 213208 | Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг | 23,876,320.50 |
| 213503 | Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, төвлөрүүлэх шилжүүлэг | |
| **II** | **ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР** | 30056414.50 |
| **1311** | **Нэмэлт санхүүжилтийн орлого** | 30,056,414.50 |
| 131104 | Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 30,056,414.50 |
| **IV** | **НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(II)-(I)** | **0.00** |
| | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл | 0.00 |
| | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл | 0.00 |

## ГУРАВ. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 5,331.2 мянган төгрөгийн алдаа[1] илэрснээс аудитын явцад санхүүгийн тайланд залруулав. Үүнд:

1. Байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээний зардлаас Оройн гурвалжин ХХК-тай 5,000.0 мянган төгрөгийн өртөгтэй "Эрдэнэцогт суманд шувууны суудал, үүр барих ажлын гэрээ"-г хийсэн ба тухайн компанийн захирал 2025 оны 05 дугаар сарын 30-ны дотор хийх хүсэлт ирүүлсэн байхад нягтлан бодогч санхүүгийн тайланд авлагаар тусгаагүй байна.Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4 дэх "Үнэн зөв байх", заалтыг зөрчсөн тул санхүүгийн тайланд авлагаар тусгаж залруулав.

[1] Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/,

2. Одоогийн сумын ИТХ-ын дарга нь багийн засаг даргаар ажиллаж байх хугацаанд нь ЗДТГ-аас 2024 оны 10 сарын цалинг бүтэн бодож олгосон бөгөөд 2024 оны 10 сарын 27-ны өдөр ИТХ-ын даргаар томилогдсон өдрөөс эхлэн 4 хоногийн цалин болох 331.2 мянган төгрөгийг сумын ИТХ-аас давхардуулан авсан байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1 дэх "Төсвийг үр ашигтай хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах" гэсэн заалтыг зөрчсөн тул санхүүгийн тайланд авлагаар тусгаж залруулав.

Аудитаар нийт 3,400.0 мянган төгрөгийн зөрчил[2] илэрснээс 3,400.0 мянган төгрөгийн зөрчлийг арилгах 1 албан шаардлага, алдаа зөрчлийг давтан гаргахгүй байх 1 зөвлөмж хүргүүлэв.

### 3.1 Албан шаардлага

1. Сумын ЗДТГ-ын даргын 2024 оны 03 дугаар сарын 18-ны өдрийн А/06 дугаар тушаалаар 2021 онд тараагдаж байсан байгууллагын санхүүгийн тайланд авлага, өглөгөөр тусгаагүй "Өрхтэй харилцах дэвтрийн үнэ"-д 3,400.0 мянган төгрөгийг бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамжийн зардлаас шилжүүлсэн байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5 дах "Батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах" Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.7 дахь "Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно." 20 дугаар зүйлийн 20.2.5 дахь “Дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах; 20.2.6 дахь “Эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах;” гэсэн заалтуудыг зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь:Цаашид санхүүгийн тайланд тусгагдаагүй тооцоо нийлсэн актаар баталгаажуулаагүй гүйлгээ хийхгүй байх албан шаардлага хүргүүлэв.

### 3.2 Зөвлөмж

1.Тус байгууллагын нярав бараа материалын гаргахдаа бараа материалыг нэр төрлөөр гаргадаггүй, тухайн сарын орлого, зарлагыг дүгнэдэггүй, сарын эхний болон эцсийн үлдэгдэл зөрүүтэй байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20.2.6 дахь “Эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах”, Сангийн сайдын 2017 оны 12 дугаар сарын 05 өдрийн 347 тоот тушаалын хавсралтаар батлагдсан НХМаягт БМ-9 Бараа материалын тайлан "Бараа материалын тайланг агуулахын нярав, эд хариуцагч нь аж ахуйн нэгж, байгууллагын бүртгэлийн бодлогын баримт бичигт заасан хугацаанд агуулахын бүртгэлд үндэслэн материалын нэр төрөл тус бүрийн тоо хэмжээгээр нэгтгэн гаргана. Бараа материалын тайланг нярав, эд хариуцагч нар дээр хөтлөгдөж

[2] Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

буй агуулахын бүртгэлтэй тулган шалгаж хүлээж авна." гэсэн зааврыг зөрчсөн байна.

**Шийдвэрлэсэн нь:** Бараа материалын тайланг нэр төрлөөр маягтын дагуу гаргаж сар бүр нягтлан бодогч тооцоог бодож байх зөвлөмжийг хүргүүлэв.

Дээрх албан шаардлага, зөвлөмжийн биелэлтийг Төрийн аудитын байгууллагад 2025 оны 05 дугаар сарын 30 -ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

-----------oOo-----------

## ДӨРӨВ. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

### Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

/мянган төгрөгөөр/

| Алдааны товч утга | Нийт алдаа | | Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан | | Буруу тусган илэрхийлсэн | | Үгнээс | | | | Зөвлөмж | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | Залруулсан | | Залруулаагүй | | | |
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн |
| Байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээний зардлаас 5,000.0 мянган төгрөгийн өртөгтэй "Эрдэнэцогт суманд шувууны суудал, үүр барих ажил" хийгдээгүй байхад зардлаар бүртгэсэн байна. | 1 | 5,000.0 | | | 1 | 5,000.0 | 1 | 5,000.0 | | | | |
| Одоогийн сумын ИТХ-ын дарга нь багийн засаг даргаар ажиллаж байх хугацаанд нь ЗДТГ-аас 2024 оны 10 сарын цалинг бүтэн бодож олгосон бөгөөд 2024 оны 10 сарын 27-ны өдөр ИТХ-ын даргаар томилогдсон өдрөөс эхлэн 4 хоногийн цалин болох 331.2 мянган төгрөгийг сумын ИТХ-аас давхардуулан авсан байна. | 1 | 332.1 | 1 | 332.1 | | | 1 | 332.1 | | | | |
| Дүн | 2 | 5,332.1 | 1 | 332.1 | 1 | 5,000.0 | 2 | 5,332.1 | | | | |

### Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

(мянган төгрөг)

| Зөрчлийн товч утга | Нийт зөрчил | | Үгнээс | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | Төлбөрийн акт | | Албан шаардлага | | Зөвлөмж | |
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн |
| Сумын ЗДТГ-ын даргын 2024 оны 03 дугаар сарын 18-ны өдрийн А/06 дугаар тушаалаар 2021 онд тараагдаж байсан байгууллагын санхүүгийн тайланд авлага, өглөгөөр тусгаагүй "Өрхтэй харилцах дэвтрийн үнэ"-д 3,400.0 мянган төгрөгийг бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамжийн зардлаас шилжүүлсэн байна. | 1 | 3,400.0 | | | 1 | 3,400.0 | | |
| Тус байгууллагын нярав бараа материалын гаргахдаа бараа материалыг нэр төрлөөр гаргадаггүй, тухайн сарын орлого, зарлагыг дүгнэдэггүй, сарын эхний болон эцсийн үлдэгдэл зөрүүтэй байна. | 1 | - | | | | | 1 | - |
| | | | | | | | | |
| Дүн | **2** | **3,400.0** | | | 1 | 3,400.0 | **1** | **0** |

----------oOo-----------